

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2.	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан/ нэмэлт санхүүжилт.....	22
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Д.БАТТОГТОХ ТАНАА

2019.02.25 № 06/220
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хүрээлэнгийн захирал Д.Баттогтох Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 10-аас 2019 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн аудитор Ц.Ганболд ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

Газарзүй, геоэкологийн хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/66 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор Газарзүйн хүрээлэн, Геоэкологийн хүрээлэн, Информатикийн хүрээлэнгийн Геоинформатикийн лабораторийг нэгтгэснээр Газарзүй геоэкологийн хүрээлэн шинээр байгуулагдсан. Хүрээлэнгийн эрхэм зорилго нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг судлах, тэдгээр салбаруудад мэдлэг, инновацийг нэвтрүүлэх замаар Монгол Улсад тогтвортой хөгжлийг хангахад чиглэнэ гэсэн эрхэм зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Тус хүрээлэн нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг судлах, тэдгээр салбаруудад мэдлэг, инновацийг нэвтрүүлэх замаар Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад чиглэн ажиллаж байна.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хүрээлэнгийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд аудитын багт мэдээллийн технологийн мэргэжилтэн ажиллах шаардлагагүй гэж үзэв.

Газарзүй, геоэкологийн хүрээлэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 4.0” програм хангамж ашигладаг байна.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэллээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Хүрээлэн нь Улсын төсвөөс санхүүжигддэг тул зардлын дүнгээс тооцох нь илүү бодитой гэж үзсэн. Учир нь зардал нь ажил гүйлгээний төрлийн эрсдэл, төлөвлөлтөөс хэтрэх, үр ашиггүй зардал гаргах зэрэг эрсдэлд өртөмтгий байх магадлалыг харгалзан үзсэн.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны нийт зардал 2,073,534.6 мянган төгрөгийн 2 хувь болох 41,470.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр, аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	3,750.0	Үндсэн хөрөнгийн элэгдэл буруу тооцсон
2	Албан шаардлага өгсөн	1	16,328.2	Тооцоо нийлж баталгаажуулаагүй.
	Дүн	2	20,078.2	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Мөнгөн хөрөнгө:

Мөнгөн кассын гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад орлого, зардлыг дутуу бүртгэсэн зөрчил гарсан. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад зөвлөмж өгч жилийн эцсийн санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан.

Урьдчилж төлсөн зардал:

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 6,033.8 мянган төгрөг байна. Үүнээс 5,038.1 мянган төгрөг нь 2012 оны 09 дүгээр сарын 01-ээс 2013 оны 05 дугаар сарын 29-ийг хүртэлх хугацаанд Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн Хяналт шалгалтын актаар 2611016413 тоот дансанд шилжүүлсэн акт, торгуулийн төлбөр байна. Хяналт шалгалтын актны төлбөрийг үүссэн тайлант хугацаанд нь зардалд бүртгээгүйгээс санхүүгийн байдал, (САГ-2019/51/СТА-ТШЗ)

үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 3 дугаар бүлгийн 18 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлагаас тухайн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах, татварын хяналт шалгалтын актны төлбөрийг харьяа татварын хэлтсүүдтэй тооцоо нийлж баталгаажуулан, тайланд үнэн зөв болгож зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэх.

ХХОАТ-ын тооцоо:

Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Геоэкологийн хүрээлэн нь Газарзүйн хүрээлэнтэй нэгдэж Газарзүй, Геоэкологийн хүрээлэн болон өөрчлөгдөн байгуулагдсан. Геоэкологийн хүрээлэн нь Сүхбаатар дүүргийн татварт бүртгэлтэй байсан бол Газарзүйн хүрээлэн нь Чингэлтэй дүүргийн татварт бүртгэлтэй байсан. Тус хоёр хүрээлэн нэгдэх үедээ харьяа татварын байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс Геоэкологийн хүрээлэн нь ХХОАТ-т 15,330.9 мянган төгрөгийн дутуу төлөлттэй, Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь ХХОАТ-т 25,625.3 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна. Тус татварын тайлангуудаарх илүү дутуу төлбөрийг бүртгэл тайланд тусгах эсэх талаар шийдвэрлээгүй. Энэ нь “Татварын ерөнхий хуулийн 3 дугаар бүлгийн 18 дугаар зүйл”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлагаас ХХОАТ-ын илүү дутуу төлөлт, татварын хяналт шалгалтын актны төлбөрийг харьяа татварын хэлтсүүдтэй тооцоо нийлж баталгаажуулан, тайланд үнэн зөв дүнгээр бүртгэж зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэх.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Өмнөх жилүүдийн бүртгэл хөтлөлттэй холбоотойгоор татварын тайлан болон санхүүгийн тайланд зөрүүтэй бүртгэсэн татварын илүү дутуу төлөлтийг шалгах.

“Нийслэлийн зураг төслийн хүрээлэн”-ээс авах 69,500.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Тус авлагыг дараагийн тайлант хугацаанд нарийвчилсан горим хэрэгжүүлэн шалгах шаардлагатай. Мөн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний тооцоололд нарийвчилсан горим хэрэгжүүлж чадаагүй. Дараагийн аудитаар авч үзэх.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,640,633.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тайлант оны үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 11,627.1 мянган төгрөг буюу 6.7%-иар хэмнэсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Газарзүй, геоэкологийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар дараах 4 зөвлөмж өгсөнөөс 3 зөвлөмж бүрэн биелүүлж 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

1. ХХОАТ-ын тооцоолол, илүү дутуу төлөлтийн дүнг харьяа татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулах талаар зөвлөмж өгсөн. Аудит хийж байх хугацаанд тус зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байсан тул хугацаатай албан шаадлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1. Балансын данстай холбоотой асуудал

3.1.1.Илрүүлэлт:

Тээврийн хэрэгслийн ашиглалтанд орсон хугацаа санхүүгийн програмд буруу оруулснаас элэгдлийн зардал 3,750.0 мянган төгрөгөөр илүү тооцсон байна.

Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал буруу тооцоологдох, улмаар санхүүгийн үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх,

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа болон элэгдлийн зардлыг зөв тооцох, хөрөнгийн ашиглалтад оруулсан хугацааг санхүүгийн програмд зөв оруулж өгөх. Анхан шатны баримт материал болон бусад дэмжих баримтыг сайтар хянаж үзсэний үндсэн дээр бүртгэл хөтөлж байх.

3.1.4.Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг сайжруулж, алдаатай бүртгэл хөтөлсөн хөрөнгүүдийг тодруулж санхүүгийн програмд засвар оруулан бүртгэл хөтөлөлтийг зөв болгож тайлагнана. “Санхүүгийн тооцоолох групп”-ээс Acolous 4.0 програмд хөрөнгийн орлогод авсан хугацааг өөрчлөх, хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл засварлах талаар зөвлөгөө авч ажиллана.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>188,035,402.29</u>	<u>122,404,500.38</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,595.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	5,595.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
33	АВЛАГА	118,053,581.57	74,324,604.66
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,641,310.47	2,042,943.59
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	106,426,379.37	70,728,829.37
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,439,660.03	00.00
335	Бусад авлага	2,546,231.70	1,552,831.70
3351	Байгууллагаас авах авлага	2,546,231.70	1,552,831.70
34	УРЬДЧИЛГАА	6,033,820.72	6,033,820.72
34600	Урьдчилж гарсан зардал	6,033,820.72	6,033,820.72
35	БАРАА МАТЕРИАЛ	63,942,405.00	42,046,075.00
351	Түүхий эд материал	00.00	31,898,300.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	31,898,300.00
354	Хангамжийн материал	63,942,405.00	10,147,775.00
35410	Бичиг хэргийн материал	287,000.00	759,750.00
35420	Аж ахуйн материал	1,019,600.00	1,032,220.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	770,000.00
35440	Түлш, шатах тослох материал	880,000.00	350,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	1,980,711.00
35470	Бусад хангамжийн материал	61,755,805.00	5,255,094.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>710,249,592.43</u>	<u>2,665,975,020.95</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	710,249,592.43	2,665,975,020.95
391	Газар	00.00	556,096,080.00
392	Биет хөрөнгө	709,633,592.39	2,108,716,607.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,056,249,578.00	1,856,422,808.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,643,932,940.37	-23,075,590.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,476,124.00	66,476,124.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-66,476,124.00	-66,476,124.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	666,126,198.96	571,937,001.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	-445,299,169.82	-376,073,872.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	208,256,668.35	214,785,168.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-161,769,748.02	-169,862,423.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	48,586,060.00	48,586,060.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-35,932,487.28	-39,470,976.36
39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,600,000.00	3,600,000.00
39217	Ном	13,749,432.57	21,868,432.57
393	Биет бус хөрөнгө	616,000.04	557,258,413.41
39301	Програм хангамж	23,899,067.00	24,663,067.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-23,283,066.96	-23,500,733.59
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	556,096,080.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>898,284,994.72</u>	<u>2,788,379,521.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>18,277,516.00</u>	<u>12,753,448.72</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,277,516.00	12,753,448.72

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

413213	Бусад зардлын өглөг	461,916.00	00.00
4136	Бусад өглөг	17,815,600.00	12,753,448.72
41361	Байгууллагад төлөх өглөг	565,600.00	11,117,348.72
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	17,250,000.00	1,636,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	880,007,478.72	2,775,626,072.61
51	Засгийн газрын хувь оролцоо	880,007,478.72	2,775,626,072.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,185,424,980.73	1,741,521,060.73
51101	Өмч: - төрийн	1,185,424,980.73	1,741,521,060.73
512	Хуримтлагдсан үр дүн	-699,320,818.96	-779,809,956.00
51210	Өмнөх үеийн үр дүн	-699,320,818.96	-714,446,018.96
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-65,363,937.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	393,903,316.95	1,813,914,967.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	898,284,994.72	2,788,379,521.33

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,882,252,443.86	2,000,185,329.61
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,642,300.00	65,281,458.70
120	Нийтлэг татварын бус орлого	21,642,300.00	65,281,458.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,642,300.00	34,838,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	30,443,158.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,860,610,143.86	1,934,903,870.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,619,927,000.00	1,616,133,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,619,927,000.00	1,616,133,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,022,162.37	318,769,970.91
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	16,991,162.37	69,753,220.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,079,000.00	235,475,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,952,000.00	13,541,250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,421,282.00	00.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	34,421,282.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	80,239,699.49	00.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	80,239,699.49	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,930,035,022.70	2,065,549,266.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,930,035,022.70	2,065,549,266.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,874,929,288.57	2,044,453,111.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,403,842,705.27	1,367,273,774.00
210101	Үндсэн цалин	1,360,645,037.47	1,348,027,866.00
210105	Гэрээт ажлын хөлс	43,197,667.80	19,245,908.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,842,292.13	165,023,737.88
210201	Тэтгэврийн даатгал	102,796,612.80	108,590,372.53
210202	Тэтгэмжийн даатгал	17,318,346.07	16,489,305.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,832,739.87	9,751,254.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,777,614.89	2,622,646.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,116,978.50	27,570,159.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,108,082.40	46,432,818.00
210301	Гэрэл, цахилгаан	16,306,538.00	16,995,871.00
210302	Түлш, халаалт	25,283,711.00	25,654,106.00
210303	Цэвэр, бохир ус	3,517,833.40	3,782,841.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,502,918.94	38,327,820.14
210401	Бичиг хэрэг	16,015,770.00	8,581,835.00
210402	Тээвэр, шатахуун	5,846,000.00	8,382,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,040,448.94	2,592,651.00
210404	Ном, хэвлэл	5,774,080.00	3,950,279.14

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,179,000.00	1,560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,647,620.00	8,181,165.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	5,079,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,402,432.00	43,344,498.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,183,800.00	00.00
210604	Урсгал засвар	24,218,632.00	43,344,498.00
2107	Томилолт, зочны зардал	58,302,255.60	47,002,700.00
210701	Гадаад албан томилолт	3,996,040.00	8,219,500.00
210702	Дотоод албан томилолт	54,306,215.60	38,783,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,236,277.40	193,965,752.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,400,073.40	188,672,672.86
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	326,700.00	326,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	317,500.00	364,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	165,000.00
210807	Газрын төлбөр	1,093,004.00	1,936,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,692,324.83	143,082,011.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,985,834.00	6,839,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,422,230.00	887,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,284,260.83	135,355,511.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,105,734.13	21,096,154.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,780,700.00	5,404,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,090,000.00	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,615,700.00	4,404,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,075,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,325,034.13	15,691,854.66
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,325,034.13	15,691,854.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-47,782,578.84</u>	<u>-65,363,937.04</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-47,782,578.84</u>	<u>-65,363,937.04</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,921,518,748.37</u>	<u>1,977,181,830.94</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,642,300.00	34,838,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,642,300.00	34,838,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,642,300.00	34,838,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,899,876,448.37	1,942,343,530.94
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,619,927,000.00	1,616,133,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,619,927,000.00	1,616,133,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139,418,942.37	326,209,630.94
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	30,387,942.37	69,753,220.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,079,000.00	242,915,160.03
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,952,000.00	13,541,250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,486,882.51	00.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	47,486,882.51	00.00
1330	Төсвийн захирагчдаас	80,239,699.49	00.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	80,239,699.49	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,803,924.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,803,924.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,901,222,748.37</u>	<u>1,953,640,175.94</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,901,222,748.37	1,953,640,175.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,838,677,354.21	1,932,544,021.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,421,100,629.27	1,366,254,741.28
210101	Үндсэн цалин	1,348,760,103.27	1,352,905,271.28
210102	Нэмэгдэл	3,382,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	68,958,526.00	13,349,470.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,483,602.60	151,844,044.00
210201	Тэтгэврийн даатгал	128,181,462.60	115,853,944.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,061,600.00	11,996,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,137,000.00	9,751,254.00

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	372,020.00	2,245,446.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,731,520.00	11,996,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,108,082.40	46,432,818.00
210301	Гэрэл, цахилгаан	16,306,538.00	17,118,221.00
210302	Түлш, халаалт	25,283,711.00	25,654,106.00
210303	Цэвэр, бохир ус	3,517,833.40	3,660,491.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,046,298.94	22,705,546.00
210401	Бичиг хэрэг	3,118,070.00	5,589,570.00
210402	Тээвэр, шатахуун	5,116,000.00	2,853,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,040,448.94	2,521,101.00
210404	Ном, хэвлэл	12,669,080.00	3,625,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,179,000.00	1,560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,923,700.00	6,556,175.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,772,537.00	30,775,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,183,800.00	700,000.00
210604	Урсгал засвар	23,588,737.00	30,075,950.00
2107	Томилолт, зочны зардал	56,917,462.00	43,569,377.00
210701	Гадаад албан томилолт	3,996,040.00	10,361,500.00
210702	Дотоод албан томилолт	52,921,422.00	33,207,877.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,226,976.00	263,171,045.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,390,772.00	257,877,965.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	326,700.00	326,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	317,500.00	364,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	165,000.00
210807	Газрын төлбөр	1,093,004.00	1,936,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,021,766.00	7,790,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	599,536.00	6,839,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,422,230.00	951,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,545,394.16	21,096,154.66
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,780,700.00	5,404,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,090,000.00	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,615,700.00	4,404,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,075,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,764,694.16	15,691,854.66
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,764,694.16	15,691,854.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>20,296,000.00</u>	<u>23,541,655.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,296,000.00	23,547,250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,296,000.00	23,547,250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,296,000.00	23,547,250.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,296,000.00	23,547,250.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-20,296,000.00</u>	<u>-23,547,250.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	-5,595.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,595.00	5,595.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,595.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,185,424,980.73	393,903,316.95	-651,538,240.12	00.00	927,790,057.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,185,424,980.73	393,903,316.95	-651,538,240.12	00.00	927,790,057.56
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-47,782,578.84	00.00	-47,782,578.84
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,185,424,980.73	393,903,316.95	-699,320,818.96	00.00	880,007,478.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-15,125,200.00	00.00	-15,125,200.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,185,424,980.73	393,903,316.95	-714,446,018.96	00.00	864,882,278.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	1,420,011,650.93	00.00	00.00	1,420,011,650.93
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	556,096,080.00	00.00	00.00	00.00	556,096,080.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-65,363,937.04	00.00	-65,363,937.04
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	-779,809,956.00	00.00	2,775,626,072.61

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,640,633,900.00	1,629,006,837.28	11,627,062.72	99.3%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,640,633,900.00	1,629,006,837.28	11,627,062.72	99.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,635,229,600.00	1,623,602,537.28	11,627,062.72	99.3%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,352,905,700.00	1,352,905,271.28	428.72	100.0%
210101	Үндсэн цалин	1,236,029,300.00	1,352,905,271.28	-116,875,971.28	109.5%
210102	Нэмэгдэл	53,064,100.00	00.00	53,064,100.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,812,800.00	00.00	57,812,800.00	
210104	Урамшуулал	5,999,500.00	00.00	5,999,500.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,949,700.00	151,400,044.00	11,549,656.00	92.9%
210201	Тэтгэврийн даатгал	108,834,800.00	115,409,944.00	-6,575,144.00	106.0%
210202	Тэтгэмжийн даатгал	13,528,800.00	11,996,700.00	1,532,100.00	88.7%
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,823,000.00	9,751,254.00	1,071,746.00	90.1%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,705,700.00	2,245,446.00	460,254.00	83.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	27,057,400.00	11,996,700.00	15,060,700.00	44.3%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,434,500.00	46,432,818.00	1,682.00	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	16,256,000.00	17,118,221.00	-862,221.00	105.3%
210302	Түлш, халаалт	26,614,500.00	25,654,106.00	960,394.00	96.4%
210303	Цэвэр, бохир ус	3,564,000.00	3,660,491.00	-96,491.00	102.7%
210304	Байрны түрээс	00.00	00.00	-	
2104	Хангамж, бараа материалын зардал	12,415,000.00	12,414,999.00	1.00	100.0%
210401	Бичиг хэрэг	2,835,000.00	2,942,880.00	-107,880.00	103.8%
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	2,365,000.00	-165,000.00	107.5%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,480,000.00	2,521,101.00	958,899.00	72.4%
210404	Ном, хэвлэл	500,000.00	659,700.00	-159,700.00	131.9%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.00	1,560,000.00	40,000.00	97.5%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	2,366,318.00	-566,318.00	131.5%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,330,000.00	30,330,000.00	-	100.0%

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	5,330,000.00	4,929,900.00	400,100.00	92.5%
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,400,100.00	-400,100.00	101.6%
2107	Томилолт, зочны зардал	18,854,000.00	18,854,000.00	-	100.0%
210701	Гадаад албан томилолт	00.00	7,524,500.00	-7,524,500.00	
210702	Дотоод албан томилолт	18,854,000.00	11,329,500.00	7,524,500.00	60.1%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,340,700.00	10,314,205.00	26,495.00	99.7%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,023,700.00	5,021,125.00	2,575.00	99.9%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	326,700.00	326,700.00	-	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,500.00	364,580.00	22,920.00	94.1%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166,000.00	165,000.00	1,000.00	99.4%
210807	Газрын төлбөр	1,936,800.00	1,936,800.00	-	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	951,200.00	48,800.00	95.1%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	951,200.00	48,800.00	95.1%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,404,300.00	5,404,300.00	-	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,404,300.00	5,404,300.00	-	100.0%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,404,300.00	4,404,300.00	-	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,640,633,900.00	1,630,139,242.28	10,494,657.72	99.4%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,616,133,900.00	1,602,140,242.28	13,993,657.72	99.1%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,616,133,900.00	1,602,140,242.28	13,993,657.72	99.1%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,500,000.00	27,999,000.00	-3,499,000.00	114.3%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,500,000.00	27,999,000.00	-3,499,000.00	114.3%

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	5,595.00	-5,595.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	158.00	158.00	-	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	133.00	133.00	-	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00	-	100.0%

4.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан/ нэмэлт санхүүжилт

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	325,649,434.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,649,434.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,109,434.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,349,470.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,349,470.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	444,000.00
210201	Тэтгэврийн даатгал	444,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,499,547.00
210401	Бичиг хэрэг	2,646,690.00
210402	Тээвэр, шатахуун	488,000.00
210404	Ном, хэвлэл	3,175,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,189,857.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,099,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,101,500.00
210604	Урсгал засвар	4,997,850.00
2107	Томилолт, зочны зардал	24,715,377.00
210701	Гадаад албан томилолт	2,837,000.00
210702	Дотоод албан томилолт	21,878,377.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,001,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	270,001,690.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	540,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	540,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	325,649,434.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	325,649,434.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	69,753,220.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	242,354,963.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,541,250.00
131106	Төсвийн урамшуулал	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын н нэр:	Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.15			САГ-2019/51/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Газарзүй, геоэкологийн хүрээлэн		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа болон элэгдлийн зардлыг зөв тооцож байгаа эсэхийг шалгаж үзэхэд зарим хөрөнгийн ашиглалтанд орсон хугацааг санхүүгийн программд буруу оруулсан байна.	3,750.0	зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Лхагвасүрэн
2	1. Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Гео-экологийн хүрээлэн нь Газарзүйн хүрээлэнтэй нэгдэж Газарзүй, Гео-экологийн хүрээлэн болон өөрчлөгдөн байгуулагдсан. Гео-экологийн хүрээлэн нь Сүхбаатар дүүргийн татварт бүртгэлтэй байсан бол Газарзүйн хүрээлэн нь чингэлтэй дүүргийн татварт бүртгэлтэй байсан. Хоёр хүрээлэн нэгдэх үедээ харьяа татварын байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх татварын тайлангаар Гео-экологийн хүрээлэн нь ХХОАТ-т 15,330.9 мянган төгрөгийн дутуу төлөлттэй, Газарзүй, гео-экологийн хүрээлэн нь ХХОАТ-т 25,625.3 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна. Тус татварын илүү дутуу төлбөрийн зөрүү 10,294.4 мянган төгрөгийг бүртгэл тайланд тусгаагүй байна. 2. Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 6,033.8 мянган төгрөг байна. Үүнээс 5,038.1 мянган төгрөг нь 2012 оны 09 дүгээр сарын 01-ээс 2013 оны	16,328.6	Албан шаардлага өгөх	Захирал	Д.Баттогтох

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<p>05 дугаар сарын 29-ийг хүртэлх хугацаанд СБД-н татварын хэлтсийн Хяналт шалгалтын 2611016413 тоот дансанд шилжүүлсэн акт, торгуулийн төлбөр байна. Хяналт шалгалтын актны төлбөрийг үүссэн тайлант хугацаанд нь зардалд бүртгээгүйгээс санхүүгийн байдал, үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн байна.</p>				
Дүн	20,078.6			

